

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Д.ТҮВШИНЗУЛ ТАНАА

2022.02.28 № 236

танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн актыг биелүүлээгүй, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхдээ байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулаагүй, батлагдсан орон тоо хэтрүүлсэн, эм болон хүнсний материалын шууд худалдан авалт хийсэн, худалдан авалтыг төлбөрийн Е баримтаар баталгаажуулаагүй, цагийн бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй, хяналт тавиагүй илүү цагийг хавтгайруулан олгосон, нярвын тайлан, анхан шатны баримтаас зөрүүтэй, 7-8 дугаар сарын шатахуун, хүнсний материалын тайлан гаргаагүй нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй, эм, хоолны өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй зэрэг зөрчлүүд нь Төрийн аудитын тухай хууль, Иргэний тухай хууль, Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам", санхүүгийн тайлангийн толилуулга, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэн зөв байдал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


0100 10049

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ, ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  С.ЦӨРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	279.30	2,601.20
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,811.10	15,940.90
	Нийт хөрөнгийн дүн	15,090.40	18,542.10
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,437.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,090.40	17,105.10
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,090.40	18,542.10
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	10,661.10	15,566.50
	Үйл ажиллагааны зардлын дүн	10,274.20	13,551.80
	Үйл ажиллагааны үр дүн	386.90	2,014.70
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	386.90	2,014.70
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,703.50	15,090.40
	Тайлант оны үр дүн	386.90	2,014.70
	Эцсийн үлдэгдэл	15,090.40	17,105.10
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	8,402.90	10,058.10
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	8,275.10	10,001.40
	Үйл ажиллагааны ЦМГ	127.80	56.70
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	- 127.80	- 36.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	- 0.00	20.70
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	343.00	10,037.40
	Урсгал зардал	343.00	10,037.40
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	7,768.70	10,058.10
	Улсын төсвөөс санхүүжих	4,566.50	
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих	234.50	413.50
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,967.70	8,298.80
	Тусламж, санхүүжилтийн орлогоос		1,345.80

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нэгдсэн эмнэлэг нь 2012 онд Засгийн газрын 2011 оны 05 сарын 11-ний өдрийн 156 дугаар тогтоолоор Бүсийн оношилгоо эмчилгээний төв болж өргөжсөн байна.

Эрхэм зорилго: Мэргэжлийн өндөр ур чадвар, нотолгоонд суурилсан, олон улсын стандартад нийцсэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн бүрд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй хүргэх.

Зорилт:

- Нээлттэй, ил тод байх
- Ёс зүйг эрхэмлэсэн
- Эелдэг харьцаа
- Аюулгүй чанартай тусламж үйлчилгээ
- Эрүүл орчин
- Мэргэшсэн мэргэжилтэн
- Эвсэг бүтээлч хамт олон гэсэн зорилт тавин мэргэжлийн 14 тасаг 267 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоол.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэх хүний нөөц, цаг хугацааны хувьд байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, бараа материал, үндсэн хөрөнгийн биет тооллого хийх аудитын цар хүрээ хязгаарлагдаж байсныг дурдах нь зүйтэй.

Мөн аудитад хийх хугацаанд аудитад шаардлагатай баримт мэдээллийг бүрэн гаргаж өгөөгүй цувруулж, дутуу ирүүлсэн, сүүлийн баримт материал, засвар хийгдсэн санхүүгийн тайланг 2022 оны 02 сарын 25-ны өдөр ирүүлж, дуудсан цагт ирэхгүй, утсаа авахгүй байх зэргээр аудит хийхэд хүндрэл учруулж байлаа.

Тус байгууллага нь 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг “САН” программаар бэлтгэсэн бөгөөд 10 сард Юникус программ шилжүүлэн жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахалтай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдалд эмнэлэг, эмнэлгийн ажилчдын ажлын ачаалал их байсан бөгөөд ажил олгогчийн зүгээс нэмэгдэл хөлс, урамшууллыг хангалтай хэмжээнд олгож ажилласан байна.

Цар тахалтай холбоотой халдвартай бүсэд ажиллах албан хаагчдыг зайлшгүй шаардлагын улмаас ээлжийн хуваарь гаргаж 7, 10 хоногуудаар үргэлжлүүлэн ажиллуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 /Ажлын дараалсан хоёр өдрийн

хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна/-д заасныг зөрчсөн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн захирагч 3 удаа солигдсон байна. Т.Оюундүү БОЭТ-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2021.01.01-2021.06.14 хүртэл, Я.Болдбаатар БОЭТ-ийн захирлаар 2021.06.14-2021.08.02 хүртэл, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Д.Түвшинзул 2021.08.02-оос эхлэн захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгчээр он дуустал ажилласан байна.

Мөн санхүү, эдийн засгийн албаны дарга буюу ерөнхий санхүүч 3 удаа солигдсон байна. Удирдлага мэдээллийн тасагт санхүү эдийн засгийн албаны даргаар Ш.Баттогтох 2021.01.01-2021.06.16 хүртэл, А.Болдмаа 2021.06.16-2021.11.09 хүртэл, Ц.Хандцоо 2021 оны 11 сарын 09-өөс он дуустал ажилласан байна.

Кассын нярваар туршилтын хугацаанд ажиллаж байсан Ш.Батдавааг 2021 оны 09 сарын 15-ны өдрөөр ажлаас чөлөөлж, кассын нярваар Ц.Балжмааг 2021 Б/212 дугаар тушаалаар томилон ажиллуулсан байна.

Эд хөрөнгийн нягтлан бодогч Т.Оюунтуул, эдийн засагч Ш.Баттогтох нар өөрийн хүсэлтээр 2021 оны 12 сарын 9-ны өдөр ажлаас чөлөөлөгдсөн байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт суларсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 150 мэдээлэл байршуулахаас 6 мэдээлэл хугацаа хоцруулан байршуулсан, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг бүрэн оруулаагүй, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төсөл байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,168,784.9 мянган төгрөгийн 17 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 460,742.1 мянган төгрөгийн 29 ажил гүйлгээ, хөрөнгө өмч зарцуулсан 63 шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, 6.1.6, 6.4.4, 6.4.5, 6.4.8-д заасантай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлж хөдөлмөрийн дотоод журмаа шинэчилсэн эсэх, өмнөх онуудын аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжүүд хэрэгжээгүй алдаа зөрчил давтагдан гарч, төсвийн захирагч, нягтлан бодогч, нярвууд ойр

ойрхон солигдож байгаа нь санхүүгийн дотоод хяналт суларч, залилан үүсэх нөхцөлийг бүрдүүлж байгаа тул 2022 онд эрсдэлийн аудит хийх шаардлагатай гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 43,334,063.1 мянган төгрөгийн 21 алдаа зөрчил илэрснээс, 7,088,914.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 144,101.5 мянган төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 36,060,473.2 мянган төгрөгийн 12 зөрчилд 5 албан шаардлага, 40,573.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1					1	
	НИЙТ	1	1					1	

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар	13	41,704.5	4	7,088.9	3	144.1	4	34,430.9	2	40.6
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	1	1,629.5					1	1,629.5		
3	Нийт дүн	14	43,334.0	4	7,088.9	3	144.1	5	36,060.5	2	40.6

